



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хот байгуулалт барилга захиалагчийн албаны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/5/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас:

www.audit.mn

Эрдэнэт хот

2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Дотоод хяналт	11
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
4.4 Материаллаг байдал	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
5.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.03.15 № 114
танай _____-ны № _____-т

“ХОТ БАЙГУУЛАЛТ БАРИЛГА,
ЗАХИАЛАГЧИЙН АЛБА”
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.БАЯРЖАРГАЛ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот байгуулалт барилга, захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хот байгуулалт барилга, захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 5 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Үүнээс томоохон хийгдсэн ажлыг дурдвал боловсон хүчнийг чадваржуулах хүрээнд төсөвчний сургалт, хөдөлмөр аюулгүй байдлын чиглэлээр Орхон аймгийн аж ахуйн нэгжүүдийн хүрээнд сургалтуудыг зохион байгуулсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	98 374 407,98	52 538 543,10
1.1.1.2	Банкинд байгаа бэлэн мөнгө	98 374 407,98	52 538 543,10
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	20 360,71	313 304,15
1.1.3.3	ХХОАТ-ын тооцоо /Суутган-1/	20 360,71	313 304,15
1.1.4	Бусад авлага		23 000 000,00
1.1.4.7	Бусад авлага		23 000 000,00
1.1.6	БАРАА МАТЕРИАЛ	7 334 240,00	13 710 330,55
1.1.6.3	Бэлэн бүтээгдэхүүн	1 941 050,00	3 941 050,00
1.1.6.4	Хангамжийн материал	4 503 190,00	8 139 280,55
1.1.6.5	Сэлбэг хэрэгсэл		
1.1.6.6	Бусад бараа материал	890 000,00	1 630 000,00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1 200 000,00	
1.1.7.1	Урьдчилж төлсөн зардал	1 200 000,00	
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	106 929 008,69	89 562 177,80
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	906 572 620,49	928 830 470,90
1.2.1	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	906 572 620,49	928 830 470,90
1.2.1.2	Барилга, байгууламж, орон сууц	17 231 943,77	17 231 943,77
1.2.1.3	Хуримтлагдсан элэгдэл. Барилга	(4 483 769,00)	(4 914 567,59)
1.2.1.6	Авто-тээврийн хэрэгсэл	49 850 000,00	49 850 000,00
1.2.1.7	Хуримтлагдсан элэгдэл	(18 129 500,00)	(23 114 500,00)
1.2.1.8	Тавилга, эд хогшил	40 008 242,73	112 073 484,17
1.2.1.9	Хуримтлагдсан элэгдэл	26 508 523,68	51 689 397,23
1.2.1.10	Компьютер, бусад хэрэгсэл	71 079 208,72	112 073 484,17
1.2.1.11	Хуримтлагдсан элэгдэл	(33 919 595,05)	(51 689 397,23)
1.2.1.12	Бусад үндсэн хөрөнгө	814 985 863,00	823 435 863,00
1.2.1.13	Хуримтлагдсан элэгдэл	(3 541 250,00)	(3 541 250,00)
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	906 572 620,49	928 830 470,90
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1 013 501 629,18	1 018 392 648,70
2.1	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өглөг	7 074 098,90	10 701 756,82
2.1.1.3.1	НӨАТ-ын тооцоо	301 446,90	10 461 947,17

Орхон аймгийн Хот байгуулалт барилга захиалагчийн албаны
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.1.1.3.2	Орлогын татварын тооцоо	6 772 652,00	239 809,65
2.1.2.6	Богино хугацаат өр төлбөрийн дүн	7 074 098,90	10 701 756,82
2.1.2.10	ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	7 074 098,90	10 701 756,82
2.3	Эзэмшигчдийн хөрөнгө		
2.3.1	Төрийн өмч	830 830 863,00	830 830 863,00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	955 462,77	955 462,77
2.3.6.1	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	955 462,77	955 462,77
	Хуримтлагдсан үр дүн	174 641 204,51	175 904 566,11
51210	Өмнөх үеийн үр дүн	140 213 557,51	174 659 206,54
51220	Тайлант үеийн үр дүн	34 427 647,00	1 245 359,57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1 013 501 629,18	1 018 392 648,70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого	466 850 680,06	478 621 420,91
1.1	Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	462 537 294,55	474 848 693,64
1.2	Ажил үйлчилгээ борлуулсны орлого		3 772 727,27
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг алдагдал	466 850 680,06	478 621 420,91
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	4 187 272,73	
9	Борлуулалт маркетингийн зардал	413 613 632,43	447 137 149,16
	Ажиллагчдын цалингийн зардал	246 906 928,00	268 027 227,36
	ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	30 700 375,00	34 575 906,10
	Албан татвар төлбөр хураамж		246 763,88
	Томилолтын зардал		2 297 454,55
	Бичиг хэргийн зардал		5 918 668,18
	Шуудан холбооны зардал		3 463 898,85
	Сургалтын зардал		8 375 009,18
	Даатгалын зардал		877 110,00
	Ашиглалтын зардал		5 374 598,25
	Засварын зардал		10 160 666,91
	Элэгдэл, хорогдлын зардал		27 186 425,04
	Түрээсийн зардал		17 291 549,09
	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал		16 911 000,00
	Тээврийн зардал		13 586 694,46
	Шатахууны зардал		7 939 409,09
	Зар сурталчилгааны зардал		936 363,64

Орхон аймгийн Хот байгуулалт барилга захиалагчийн албаны
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	Бусад зардал		23 968 404,58
10	Ерөнхий удирдлагын зардал		29 086 175,25
	Ажиллагсдын цалингийн зардал		25 736 063,33
	ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал		3 350 111,92
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	7 847 360,48	912 927,27
	Үйл ажиллагааны бусад зардал		912 927,27
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз/ гарз		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз/гарз		
16	Хөрөнгө оруулалт борлуулсны үүссэн олз/гарз		
17	Бусад ашиг /алдагдал		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг / алдагдал	41 202 414,63	1 485 169,22
19	Орлогын татварын зардал	6 774 767,63	239 809,65
	Тайлангийн үеийн орлогын татварын зардал		239 809,65
20	Татварын дараах ашиг/ алдагдал	34 427 647,00	1 245 359,57
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг/ алдагдал		
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал	34 427 647,00	1 245 359,57
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	ОРЛОГЫН НИЙТ ДҮН	34 427 647,00	1 245 359,57

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
Залруулсан үлдэгдэл	830 830 863,00	955 462,77	174 659 206,54	1 006 445 532,31
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гарсан өөрчлөлт				
Зарласан ногдол ашиг				
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал			1 245 359,57	1 245 359,57
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	830 830 863,00	955 462,77	175 904 566,11	1 007 690 891,88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөр дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
1.1	Мөнгөн орлогын дүн	503 483 563,00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	503 483 563,00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	

Орхон аймгийн Хот байгуулалт барилга захиалагчийн албаны
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1.1.4	Буцаан авсан албан татвар	
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	
1.2	Мөнгөн зарлагын дүн	496 263 824,88
1.2.1	Ажилчдад төлсөн	237 156 522,99
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	72 914 403,13
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	27 192 340,00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5 901 251,04
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8 729 350,00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	57 275 171,57
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	87 094 786,15
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	7 219 738,12
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
2.1	Мөнгөн орлогын дүн	
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	
2.2	Мөнгөн зарлагын дүн	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	53 055 603,00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	
2.2.3	Хөрөнгө оруулал олж эзэмшихэд төлсөн мөнгө	
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	
2.3	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(53 055 603,00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
3.1	Мөнгөн орлогын дүн	
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	813 426,00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	
3.1.3	Төрөл бүрийн хандив	
3.2	Мөнгөн зарлагын дүн	
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	813 426,00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	
3.2.3	Хувьцаа буцаан авахад төлсөн	
3.2.4	Төлсөн ногдол ашиг	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	
4	Валютын ханшийн зөрүү	
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(45 835 864,88)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	98 374 407,98
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	52 538 543,10

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Орхон аймгийн Хот байгуулалт барилга захиалагчийн алба нь “Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэвшилтэт технологид суурилсан, чанартай бүтээн байгуулалтын үр өгөөжийг дээшлүүлж, Эрдэнэт хотын хөгжилд хувь нэмэрээ оруулах зорилготой ажиллаж байна. Мөн барилга, хот төлөвлөлт, газрын харилцаа, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, аймгийн хэмжээнд тулгараад байгаа эдийн засаг, нийгмийн бэрхшээлтэй асуудлуудыг цогцоор шийдэн, хөгжлийг жигд хангах замаар хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах Монгол Улсын Засгийн Газрын зорилгыг баримталж ажиллана.

Орхон аймгийн Хот байгуулалт барилга захиалагчийн алба нь 2021 онд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд :

- Барилгын стандарт, норм нормативын баримт бичгийн заалтыг хэрэгжүүлэх.
- Орхон аймгийн нутаг дэвсгэрт бүх барилга, байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтанд оруулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах, хяналт тавих, иргэдийн эрүүл аюулгүй, ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь заалтуудтай нийцэж байна.

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тогтоол 2021 оны 200 дугаар тогтоол болж өөрчлөгдөж, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, барилгын ажил ашиглалтад оруулах, барилгын төвөгшлийн ангилал 2021 онд 211, 212, 213 дугаар тогтоол болж өөрчлөлт орсон.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3.-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн тэтгэврийн даатгал-ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, тэтгэврийн даатгал-даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, шимтгэлийн дүн-ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх

шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, шимтгэлийн дүнд даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсөн.

- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолд 2021 оны 207 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж 1 дэх заалтын "7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл" гэснийг "12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал" гэж өөрчилсөн.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хот байгуулалт барилга, захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	98,374.4	52,538.5	(45,835.9)
Авлага	20.4	23,313.3	23,292.9
Бараа материал	7,334.2	13,710.3	6,376.1
Үндсэн хөрөнгө	906,572.6	928,830.5	22,257.9
Нийт хөрөнгө	1,013,501.6	1,018,392.6	4,891.0
Өр төлбөр	7,074.1	10,701.8	3,627.7
Эздийн өмч	830,830.9	830,830.9	0.0
Хуримтлагдсан үр дүн	174,641.2	175,904.6	1,245.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	955.5	955.5	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,013,501.6	1,018,392.6	4,891.0

Банкин дахь мөнгөний эхний үлдэгдэл 98,374.4 мянган төгрөг байсан ба 52,538.5 мянган төгрөг болж 45,835.9 төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл нь 23,313.3 мянган төгрөг болж өмнөх оноос 23,292.9 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын авлага 292.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, "Их хаадын цуваа" ХХК-ийн 15,000.0 мянган төгрөг, "Бет-Андууд" ХХК-ийн 8,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн ажлын авлагаар өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл нь 13,710.3 мянган төгрөг болж өмнөх оноос 6,376.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 26,185.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 19,809.3 мянган төгрөгийн бараа материал зарлагдсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 928,830.5 мянган төгрөг болж өмнөх оноос 22,257.9 мянган төгрөгөөр өссөн нь компьютер дагалдах хэрэгсэл 40,994.3 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 8,450.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн элэгдэл хорогдлын дүнгээр буурснаас хамаарч байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 10,461.9 мянган төгрөгийн НӨАТ-ын өр, 239.8 мянган төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өр байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт компанийн тайлант хугацаанд гарсан өртөг, зардлыг ашиглалт, засвар, үйлчилгээ, ерөнхий удирдлага, борлуулалт маркетинг гэсэн өртгийн төвүүдэд аккрузл сууриар бодитой, үнэн зөв тооцож, тайлант хугацаанд нь зохистой ангилж, хуваарилж бүртгэх, үйл ажиллагааны бусад зардлыг аккрузл сууриар зөв, тооцож бүртгэхээр заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

3.4. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хот байгуулалт барилга, захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хот байгуулалт барилга, захиалагчийн алба ОНӨААТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөлөөр 573,936.2 мянган төгрөгийн орлого, 569,970.9 мянган төгрөгөөр зарлагыг тооцож батлуулсан.

Тайлант онд гүйцэтгэлээр 478,621.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 476,223.3 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 912.9 мянган төгрөгийн үйл ажиллагааны бус зардал гаргаж, 1,245.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 478,621.4 мянган төгрөг болж төлөвлөснөөс 95,314.8 мянган төгрөг буюу 16.6 хувиар дутуу бүрдүүлсэн байгаа нь батлагдсан орлогын төлөвлөгөөг НӨАТ-тэй дүнгээр тооцоолж батласан ба ажил гүйцэтгэл дууссан мөнгө нь орж ирсэн орлогыг төлөвлөгөөнд тусгасан байсантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 476,223.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 93,747.6 мянган төгрөг буюу 16.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

Тайлант хугацаанд Эрдэнэт сангаас 4,150.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, сургалтын зардалд 2,345.2 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1,804.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хот байгуулалт барилга, захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зардал, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2

болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Хот байгуулалт барилга, захиалагчийн алба ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн А/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн үед мөрдөгдөж байсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байна.

Тайлант онд тус байгууллагын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл болон санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах байгууллагаас 2021 оны 10-р сард санхүүгийн хяналт, шалгалт хийгдсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын хэлтсийн дотоод аудитор тайлант онд аудитын ажлын төлөвлөгөө боловсруулж, шилэн данс, өр авлагын харьцаа, барагдуулалт, анхан шатны баримтжуулалт, цалин бодолт зэргийг хянаж, санхүүгийн үйл ажиллагааг НББОУС-ын дагуу хөтөлж, тайланг хуулийн хугацаанд гаргаж хэвшсэн, зөрчилгүй гэж үнэлжээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хот байгуулалт барилга, захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 573,936.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,739.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,017. 6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймгийн Хот байгуулалт барилга захиалагчийн алба нь 2021 онд нийт 537,166.7 мянган төгрөгийн 145 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас, 3 мэдээ мэдээлэх хугацаа болоогүй, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын 2 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож, 537,166.7 мянган төгрөгийн 140 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин анхан шатны баримтыг хүчин төгөлдөр баримтаар хөтлөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон нийт 1,211.0 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 310.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 800.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 101.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	2	310.0	2	310.0			
Албан шаардлага	1	800.0	1	800.0			
Зөвлөмж	2	101.0	2	101.0			
Нийт дүн	5	1,211.0	5	1,211.0			

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд өглөг авлагыг хянаж, тайлант оны эцэст үлдсэн өглөг авлагын үлдэгдлийг баталгаажуулж, тооцоо нийлсэн акт болон холбогдох эрх зүйн баримтыг тулган баталгаажуулах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 38,784.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 266.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, 3,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 35,018.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж хүргүүлсэн.

Залруулагдаагүй 38,784.9 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 5,739.4 мянган төгрөгийн түвшнээс 33,045.5 төгрөгөөр их байгаа хэдий ч үүнээс 34,014.7 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг бус тул зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар гаргасан алдаа зөрчилд залруулсан алдаа зөрчил илрээгүй болно

4.2 Албан шаардлага

Төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлээгүй 3,500.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн тул тус зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Шилэн дансанд 2 мэдээлэл хоцроож Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтуудыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.

4.3 Төлбөрийн акт

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, и-баримтгүй 266.0 мянган төгрөг зарцуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага өглөгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст 23,313.0 мянган төгрөгийн авлага, 10,701.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Тайлант оны эцэст авлага, өр төлбөр үүсгэхгүй байж, тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулах.

2. Биеет бус хөрөнгийн тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Ашиглалтын хугацаа дууссан биет бус хөрөнгө 900.0 мянган төгрөгийн Smart санхүүгийн программд хорогдуулга тооцоогүй өртөгөөрөө санхүүгийн тайланд бүртгэлтэй байна. Энэ нь НББОУС 38 "Биет бус хөрөнгө" стандартын 15-р параграфийн "...биет бус хөрөнгөд хорогдуулга тооцож, тайлагнах" гэсэн заалтыг баримталж ажиллаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Биет бус хөрөнгөд ашиглалтын хугацаагаар хорогдуулга тооцож, үлдэх өртөггүй болсон үед данснаас хасаж актлах.

3. **Нийгмийн даатгалын тайлагналтай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 32.1-д "Дараахь хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна.", 32.1.2-д "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс" гэсэн заалтыг баримталж ажиллаагүй, сургалт зохион байгуулахад гэрээгээр багшилсан багш нарын ажлын хөлс болох 250.0 мянган төгрөгөөс 49.0 мянган төгрөгийн НДШ тооцоогүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Гэрээгээр ажил гүйцэтгэгчийн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож тайлагнах.

4. **Цалингийн тооцоололтой холбоотой асуудал**

4.1. Илрүүлэлт:

Ерөнхий инженерийн түр орлон гүйцэтгэх хугацааны нэмэгдэл цалинг 17.5 мянган төгрөгөөр илүү тооцсон. Мөн ерөнхий төсөвлөгчийн цалинг 37.7 мянган төгрөг буюу 1 хоногоор дутуу тооцоолсон байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Цалинг тооцоходоо татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомж, заавар журмын дагуу зөв бодож татвар нийгмийн даатгалын тайлангуудтай тулган баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл


Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн нэгтгэл		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хот байгуулалт барилга захиалагчийн алба	7	38,784.9			1	266.0	1	3,500.0	5	35,018.9
Нийт дүн		7	38,784.9			1	266.0	1	3,500.0	5	35,018.9

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ийн ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:



Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:




6117143690
ΦΑΑ0073 9042808

Ц.НАРМАНДАХ